



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/581

Есөнбулаг

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Солонго дулааны станц" ААТҮГ-ын өмчид бүртгэлтэй Солонго хороололд байрлах 5 ширхэг 6/04 кВ-ын дэд өртөө, 7250 метр 6кВ-ын кабель магистраль шугамыг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-д шилжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Хаш-Эрдэнэ

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүдэд:

З.Жаргалтуяа

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Отгонжаргал

(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

Д.Баярчулуун

("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ерөнхий инженер)

Н.Батбаяр

("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн ашиглалт, засварын хэлтсийн дарга)

Ж.Түмэнжаргал

("Солонго дулааны станц" аж ААТҮГ-ын захирал)

Ж.Билэгсайхан

(Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Д.Содномдаржаа

("Солонго дулааны станц" ААТҮГ-ын ерөнхий инженер)

2.Байгууламжийн холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, хэвийн ажиллагааг шалган, хөрөнгийг шилжүүлэн үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Л.Хаш-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг хүлээж авсан акт, баримт бичгийг үндэслэн хөрөнгийг шилжүүлэн ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, байгууламжийн урсгал засвар, үйл ажиллагааны зардлыг төсөвт тусгах, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтыг хариуцаж ажиллахыг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК (М.Балдорж)-д тус тус даалгасугай.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ХАРИУЦСАН
ОРЛОГЧ

Д.БАТБИЛЭГ